

**ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН БИЕЛЭЛТ**

Д/д	Хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин	Биелэлт
1.	Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах	Төлөвлөгөөний тоо	1	1	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж байгууллагын албан ёсны цахим хуудаст нээлттэй ил тод байршуулан хэрэгжилтийг ханган ажилласан. Тус газрын 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан.
2.	Сургалтын хөтөлбөр боловсруулж батлах, хэрэгжилтийг хангаж ажиллах	Төлөвлөгөөний тоо	1	1	Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны сургалтын календарчилсан төлөвлөгөөг боловсруулан баталж байгууллагын албан ёсны цахим хуудаст нээлттэй ил тод байршуулан хэрэгжилтийг ханган ажилласан.
3.	Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн талаарх хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Сургалтын тоо	2	2	2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр “Бонум” ХХК-ийн Бизнес хөгжил хариуцсан захирал М.Тэмүүлэнг урьж “Өөрийгөө бүтээхүй” сургалтыг цахим болон танхим хосолсон хэлбэрээр зохион байгуулж байгууллагын нийт албан хаагчийг хамруулсан. 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 01/464 дугаартай албан бичгээр Монгол Улсын Ёс зүйн хороонд байгууллагын нийт албан хаагчдад сургалт авах хүсэлтийг хүргүүлж 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдөр Ёс зүйн хорооны Соён гэгээрүүлэх хэлтсийн дарга Ц.Заяхүү, Соён гэгээрүүлэх хэлтсийн дэд хороо хариуцсан ахлах мэргэжилтэн Мөнхжин нар “Байгууллагын соёл, албан хаагчийн ёс зүй” сэдвээр сургалт зохион байгуулж байгууллагын нийт 154 албан хаагчийг хамруулсан.
4.	Шинээр ажилд орсон албан хаагчдад ёс зүйн асуудлаар сургалт зохион байгуулахад	Сургалтын тоо	8	6	Шинээр ажилд орсон 6 албан хаагчид 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр тус газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны үйл

	холбогдох нэгжтэй хамтран ажиллах				ажиллагаа, холбогдох асуудлын талаар сургалтыг тус газрын Захиргаа удирдлагын газартай хамтран зохион байгуулсан. 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Систем нэгтгэлийн хэлтэс дээр томилогдсон 1, ХАХҮХ-т томилогдсон 2 албан хаагчид Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн тухай сургалтыг тус газрын Захиргаа удирдлагын газартай хамтран зохион байгуулж нийт 3 албан хаагчийг хамруулсан. 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр Систем нэгтгэлийн хэлтэст томилогдсон 1, үйлчилгээний нэгдсэн төвийн зохицуулалтын газрын Аймаг хариуцсан хэлтэст томилогдсон 1 албан хаагч, Систем нэгтгэл, сургалт хөгжлийн хэлтэст томилогдсон 1 албан хаагчид Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомжийн тухай сургалтыг тус газрын Захиргаа удирдлагын газартай хамтран зохион байгуулж нийт 3 албан хаагчийг хамруулсан. 2025 оны 11 дүгээр сарын 04, 05-ны өдрүүдэд нийслэлийн шинээр томилогдсон албан хаагчдад Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж журамтай холбоотой 2 удаагийн сургалт зохион байгуулж 14 албан хаагчийг хамруулсан. 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн “7:4:10” цахим мэдээллийн цагийн хөтөлбөрийн “Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалтад нийт албан хаагчийг хамруулсан.
5.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг хянан шалгаж, дүгнэлт гаргах	Дүгнэлтийн тоо	Тухай бүр	4	Удирдах албан тушаалтантай холбоотойгоор 2024 онд ирүүлсэн 2 гомдлыг 2025 оны 01 дүгээр сард “Ёс зүйн зөрчил гаргасан тухай” дүгнэлт хүргүүлсэн.

					2025 оны 02 дугаар сард ирсэн гүйцэтгэх албан хаагчтай холбоотой 1 гомдлыг хянан шалгаж ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдон холбогдох дүгнэлтийг хүргүүлсэн. 2025 оны 04 дүгээр сард төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтантай холбоотой 1 ирснийг хянан шалгаж зөрчил тогтоогдоогүй тухай дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. 2025 оны 04 дүгээр сард төрийн үйлчилгээний гүйцэтгэх албан тушаалтантай холбоотой 1 гомдол ирснийг хянан шалгаж зөрчил тогтоогдоогүй тухай дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлсэн. 2025 оны 06 дугаар сард төрийн үйлчилгээний удирдах албан тушаалтай холбоотой 1, гүйцэтгэх албан тушаалтантай холбоотой 1 гомдол ирснийг хянан шалгаж зөрчилгүй гаргаагүй тухай дүгнэлтийг холбогдох албан хаагчдад хүргүүлсэн. Нийт 7 гомдол ирсэн байна.
6.	Холбогдох нэгжүүдэд ёс зүйн асуудлаар зөвлөмж өгөх	Хүргүүлсэн зөвлөмжийн тоо	5	2	Байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийг таниулах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шинээр ажилд орсон ажилтнуудыг чиглүүлэх сургалтыг зохион байгуулахад холбогдох журмын дагуу хамтран ажиллах тухай У-03/01 дугаартай албан бичгээр Захиргаа удирдлагын газар болон Сургалт хөгжлийн хэлтэст тус тус зөвлөмж хүргүүлсэн.
7.	Байгууллага, нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа хийх	Судалгааны тоо	2	2	Байгууллага, нэгж дотроо гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ээлжит судалгааг 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдөр авч үр нэгтгэн тайлагнаж ажилласан. Цахим ур чадвар, олон нийттэй харилцах газрын нийт албан хаагчдаас нэгж дотор гарч байгаа болон үүсэж болзошгүй ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан, нөхцөл, эрсдэлийг

					тооцох, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор судалгаа авч нэгтгэсэн.
8.	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, ажлын тайлан, мэдээг гаргаж Ёс зүйн хороонд хүргүүлэх	Тайлангийн тоо	2	3	Ёс зүйн зөрчлийн бүртгэл хяналтын дэд системд 2024 оны үйл ажиллагааны тайланг, өргөдөл гомдлын бүртгэлийг нөхөж оруулсан. 2025 онд ирсэн 1 гомдлыг системд бүртгэл үүсгэсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо, Ёс зүйн хороонд тус газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөөний нэгдүгээр улирал, хагас жил, гурав дугаар улирлын байдлаар биелэлтийг хүргүүлсэн.
9.	Ээлжит хуралдааныг жил бүрийн 6, 12 дугаар сарын сүүлийн долоо хоногт зохион байгуулах	Хуралдааны тоо	2	1	Тус хорооны нэгдсэн хуралдааныг 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулж жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар хэлэлцсэн.
10.	Ёс зүйн зөрчил гаргасан талаар гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх хуралдааныг тухай бүр зохион байгуулах	Хянан шийдвэрлэсэн гомдол мэдээллийн тоо	Тухай бүр	11	2025 онд удирдах албан тушаалтантай холбоотой 3, үйлчилгээний ажилтантай холбоотой 1, төрийн захиргааны албан хаагчтай холбоотой 2, төрийн үйлчилгээний гүйцэтгэх албан тушаалтантай холбоотой 1 гомдлыг хянан шалгаж холбогдох албан тушаалтанд дүгнэлт хүргүүлсэн. Тус гомдлыг хянан шийдвэрлэх, хариуцлага хүлээлгэх, тодруулга авах тухай 8 удаагийн хурлыг зохион байгуулж албажуулсан.
11.	Ёс зүйтэй албан хаагчийг алдаршуулах ажлыг зохион байгуулах	Арга хэмжээний тоо	4	3	2025 оны 08 дугаар сарын 26-ны өдөр нийт албан хаагчдын дунд санал асуулга явуулж байгууллага, хамт олноо ёс зүйгээр манлайлагч 3 албан хаагчийг шалгаруулсан.

Тайлагнасан:
Цахим ур чадварын хэлтсийн дарга

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга

.....

/Н.Алтансүвд/

.....